



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

2014-2017

Танилцуулга гаргасан мэргэжилтэн: Б.Лхагвасайхан

УЛААНБААТАР 2018

ӨМНӨХ ҮГ

Сонгинохайрхан дүүргийн бизнес регистрийн санд барилгын салбарын чиглэлээр бүртгэлтэй нийт 1888 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байгаагаас 521 байгууллага буюу 27.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.

Ойлголт, тодорхойлолт

Объект гэж бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажлыг хэлнэ.

Барилга байгууламж гэж олон төрлийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах байгууламжийг хэлнэ.

Барилга угсралт, их засварын ажил гэж барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламжийг ойлгоно.

Орон сууцны бус барилга-д барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%- аас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

Инженерийн барилгын ажил-д төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажлыг оруулна.



БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ


Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагууд 2017 онд 85988 сая төгрөгийн барилга ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 100169.6 (53.8%) сая төгрөгөөр буурсан байна. 2017 онд ашиглалтад оруулсан барилгаас 22075.6 (25.7%) сая төгрөгийн орон сууцны, 11694.0 (13.6%) сая төгрөгийн сургууль цэцэрлэг спортын, 900.0 (1.0%) сая төгрөгийн худалдаа үйлчилгээний, 14462.7 (16.8%) сая төгрөгийн авто зам, гүүр байна.

Хүснэгт 1. Ашиглалтад оруулсан үндсэн хөрөнгө, сая төгрөгөөр

Барилгын төрөл	2014	2015	2016	2017
Бүгд	133613.7	201235.1	186157.6	85988.0
Орон сууцны	106330.0	141800.0	93630.0	22075.6
Худалдаа үйлчилгээний барилга	2500.0	2000.0	3489.4	900.0
Сургууль, цэцэрлэг, спортын	4157.1	6138.7	26306.3	11694.0
Авто зам, гүүр	-	13388.0	13333.7	14462.7
Бусад	20626.6	37908.4	49398.2	36855.7

Барилгын компаниуд 2016 онд 186157.6 сая төгрөгийн барилга ашиглалтад оруулснаас 93630 (50.3%) сая төгрөгийн орон сууцны, 3489.4 (1.9%) сая төгрөгийн худалдаа үйлчилгээний, 26306.3 (14.1%) сая төгрөгийн сургууль, цэцэрлэг, спортын, 13333.7 (7.2%) сая төгрөгийн авто зам, гүүрний барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулсан байна. 2015 онд 201235.1 сая төгрөгийн барилга ашиглалтад оруулснаас 141800,0 (70.5%) сая төгрөгийн орон сууцны, 2000,0 (1%) сая төгрөгийн худалдаа үйлчилгээний, 6138,7 (3.1%) сая төгрөгийн сургууль, цэцэрлэг, спортын, 13388,0 (6.7%) сая төгрөгийн авто зам гүүрын барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Зураг 1. Ашиглалтанд оруулсан орон сууц, хүчин чадлаар



Зураг 2. Сургууль, цэцэрлэг, спортын барилгын үндсэн хөрөнгө БУИЗА-ын нийт үндсэн хөрөнгөд эзлэх хувиар




388 айлын орон сууц ашиглалтанд орсон нь өмнөх оноос 1569 айлаар, 2015 оноос 3479 айлаар , 3 жилийн өмнөхөөс буюу 2014 оноос 1659 айлаар тус тус буурсан байна. 2017 онд 740 хүүхдийн суудалтай сургууль ашиглалтанд орсон нь өмнөх оноос 2.5 дахин буурч , 2015 оноос 1.4 дахин буурч ,2014 оноос 1.7 дахин өссөн байна. 2017 онд 610 хүүхдийн суудалтай цэцэрлэг ашиглалтанд орсон нь өмнөх оноос 80 хүүхдээр цөөн байна. 2014, 2015 онд ашиглалтанд орсон хүүхдийн цэцэрлэг байхгүй байна.

Хүснэгт 2. Ашиглалтанд оруулсан барилга угсралтын ажил , хүчин чадлаар

Барилгын төрөл	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017
Орон сууцны барилга	айлын тоо	2047	3867	1957	388
Худалдаа үйлчилгээний барилга	м2	4520	3643	6831.5	1300
Сургууль	суудлын тоо	420	1060	1900	740
Цэцэрлэг	хүүхэд	-	-	690	610
Спортын барилга	м2	1800	600	10030	-
Авто зам, гүүр	км	-	4	11	3.9
Бусад	м2	2686.4	2198.4	5719	1930

Дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил хийсэн байгууллагууд 2017 онд 1300 метр² бүхий худалдаа үйлчилгээний барилга ашиглалтанд оруулсан нь өмнөх оноос 5.2 дахин буурсан байна. 2017 онд 3.9 км авто зам ашиглалтанд оруулсан нь төрийн өмчийн бөгөөд өмнөх оноос 2.8 дахин буурсан байна. Спортын барилга байгууламж 2017 онд ашиглалтанд ороогүй бөгөөд 2016 онд 10030 метр² талбай бүхий спортын барилга байгууламжийг ашиглалтанд оруулсан байна.

Зураг 3. Төрийн өмчийн ашиглалтанд оруулсан авто зам, км



2017 онд төрийн өмчийн 1652 метр² талбайтай сургууль цэцэрлэгийн барилга ашиглалтанд орсон байна. Энэ нь нийт төрийн өмчийн барилгын байгууламжийн 13.6 хувь болж байна.


Нийт ашиглалтад оруулсан барилгын 64.4 хувь нь төрийн өмчийн, 35.6 хувь нь хувийн өмчийнх байна. Хувийн өмчийн компаниудын ашиглалтад оруулсан барилгын 25.7 хувь нь орон сууцны, 1.0 хувь худалдаа үйлчилгээний барилга байна.

Хүснэгт 3. Барилга угсралт, их засварын ажил, барилгын төрлөөр, өмчийн хэлбэр, хувиар

Барилга угсралт их засварын ажил бүгд	2014	2015	2016	2017
	Төрийн			
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0
Дүн	18.1	24.1	32.5	64.4
Орон сууцны бус бусад барилга	2.8	-	3.5	5.9
Сургууль, цэцэрлэг, спортын	1.2	1.8	10.8	13.6
Авто зам	-	6.7	7.2	12.3
Бусад	14.1	15.6	11	32.4
	Хувийн			
Дүн	81.9	75.9	67.5	35.6
орон сууц	79.6	70.5	48.4	25.7
Худалдаа үйлчилгээний	1.9	1	12.9	1
Сургууль, спорт биеийн тамир	0.4	1.4	3.4	-
Бусад	-	3	2.8	8.9

2014 онд төрийн өмчийн 3062 (2.8%) метр² талбайтай орон сууцны бус бусад барилгыг ашиглалтанд оруулж, сургууль, цэцэрлэг, спортын 1200 (1.2%) метр², 2015 байдлаар төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, спортын 3286 (1.8%) метр², 4 (6.7%) км авто замыг ашиглалтанд оруулж, 2016 оны байдлаар төрийн өмчийн 360 (3.5%) метр² орон сууцны бус бусад барилгыг ашиглалтанд оруулж, сургууль, цэцэрлэг спортын 18578,5 (10.8%) метр², авто зам 11 (7.2%) км авто замыг ашиглалтанд оруулсан байна.

Зураг 4. Хувийн байгууллагын гүйцэтгэсэн БУИЗА, хувиар



2017 онд төрийн өмчийн ашиглалтад оруулсан барилгын 5.9 хувь нь орон сууцны бус бусад барилга, 13.6 хувь нь сургууль, цэцэрлэгийн барилга, 2.3 хувь нь авто зам байна.